



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/530

Эрдэнэт

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 1.1.9.5, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүүлийн зорилтод бүлгийн /15-34 насны залуучууд/ хүн амд эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, эмчилгээ хийх ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах зардал 15000000/ Арван таван сая / төгрөгийг "Зорилтот бүлгийн хүн амд ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлэх зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Буман сор/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ